



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
САЙНЦАГААН СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН  
ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 03 сарын 31 өдөр

Дугаар 18

Мандалговь


“Эхийн алдар” одонгоор  
шагнуулахаар уламжлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх, Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсгийн 4.1.2 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2011 оны 116 дугаар зарлигаар батлагдсан “Эхчүүдийг алдарт эхийн нэг, хоёрдугаар одонгоор шагнах тухай” журмыг тус тус үндэслэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаас ТОГТООХ нь :

1. Олон хүүхэд төрүүлж өсгөж одон авах болзол хангаж хүсэлтээ ирүүлсэн 6-р багийн иргэн Нямсүрэн овогтой Отгоныг “Эхийн алдар” нэгдүгээр одонгоор шагнуулахаар дэмжиж аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд уламжилсугай.

2. “Эхийн алдар” нэгдүгээр одонгоор шагнуулах эхийн анкетыг хавсралтаар баталсугай.

3. Холбогдох материалыг хууль, журмын дагуу бүрдүүлэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албанд хүргүүлэхийг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга (Б.Эрдэнэтуяа)-д даалгасугай.

ДАРГА  Т.БАТЖАРГАЛ